

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Хишигбаатар Саруул

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<p>1.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих</p>							
1	Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ сунгах арга хэмжээг зохион байгуулсан байх, хувиар	ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах арга хэмжээг зохион байгуулсан байх, хувиар	2024 онд ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 18 зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.	Зөвлөмж ирсэн тухай бүр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /улсын хэмжээнд/-ын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу холбогдох гэрээнүүдийн төслийг боловсруулсан. Тухайлбал: 1.Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p> үйлчилгээний цогцолборын зураг төсөв /Архангай, Эрдэнэбулган сум/ 2.Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн өргөтгөлийн барилгын тухайлсан зураг төсөв, 350 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ 3."Дипломат хаус" олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төвийн зураг төсөв /Улаанбаатар хот/ 4.Байгалийн түүхийн музейн интерьерийн зураг төсөв /Улаанбаатар хот/ 5.Цагдаа, дотоодын цэргийн сургалтын төвийн Сургалт, соёл, спортын цогцолборын барилга /Улаанбаатар хот/ 6.Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнүүдийг болон 7. "Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг" төслийн хүрээнд Багц-1 буюу "Биотехнологийн төвийн молекул биологи, </p>	
--	--	--	--	--	--	--

					генетикийн суурь лабораторийн багаж тоног төхөөрөмж" нийлүүлэх гэрээний төслийг тус тус боловсруулж байгуулсан бөгөөд дээрх гэрээт ажлуудын гүйцэтгэлийн явц хэвийн байгаа болно. 2024 оны зөвлөх үйлчилгээний гэрээнүүдээс нийт 13-аас 5 гэрээт ажлын үр дүнг хүлээн авч, 8 гэрээний үндэслэлийг шалгаж, талуудтай харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, тус гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, боловсруулж, хэрэгжилтийг хангуулж, хугацааг сунгасан болно. Боловсролын яамнаас шилжиж ирсэн Барилга угсралтын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээнд өөрчлөлт оруулан байгуулсан болно.		
2	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж	Гүйцэтгэлийн явц, хувиар	2024 онд байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн	Удирдлагаас хуваарилсан байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн	2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гадагшаа чиглэсэн 61 албан бичгийн төсөл, бусад нэгжүүдэд чиглэсэн 35 дотоод бичгийн төсөл болон нууцын бичгийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

<p>зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ</p>		<p>төслүүдийг тухай бүр хянасан байна.</p>	<p>төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/</p>	<p>төслүүдийг (боловсруулсан нууцын бичгийн төслийн тоо нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар нууцын зэрэглэлд хамаардаг тул тайлагнах боломжгүй) боловсруулж хүргүүлсэн. Teams платформ дээр нэгжийн даргаас "Assign" хийж хянуулахаар ирүүлсэн албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан болно./Нийт 46 албан бичгийн төсөл/ Мөн түүнчлэн дараах ажлын хэсэгт орж ажилласан болно: 1.Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах АХ; 2.Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төсөл боловсруулах АХ; 3.Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн АХ; 4.Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах тухай АХ; (Хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулж, орчуулж, хэлэлцээр байгуулах бүх үйл</p>	<p>сар, 11-р сар, 12-р сар</p>	
--	--	--	---	--	--------------------------------	--

					<p>ажиллагааг хариуцсан) 5.Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ийн албаны дарга сонгон шалгаруулах нийт 6 үнэлгээний хорооны гишүүн (Сонгон шалгаруулалтын зарыг боловсруулан тухай бүр байгууллагын пэйж хуудсан дээр байршуулсан); 6.ОХУ- ын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтын судалгааны АХ; 7.АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй ASDIP төслийн хүрээнд гэрээний хэлэлцээр хийх үүрэг бүхий АХ; 8.Яамны холбогдох гэрээнүүд дүгнэх АХ (Хурлын протокол үйлдэж, гэрээ дүгнэсэн акт боловсруулж батлуулсан); 9.ШУА-ийн Философийн хүрээлэнгийн хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, газар дээр нь хяналт шалгалт зохион байгуулах АХ; 10.МУ-БНСУ хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулах АХ; 11.Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хэлэлцээрийн хамтарсан АХ; 12.Салбарын албаны</p>	
--	--	--	--	--	--	--

					нууцын жагсаалт шинэчлэх АХ; 13.МХБ-ын үйл ажиллагааг сэргээх асуудлыг судлах АХ.		
3	Монгол Улсын Засгын газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр төлөөлж, нийтийн ашиг сонирхлыг хамгаална	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлсэн байх, хувиар	2024 онд Монгол Улсын Засгийн газар болон ЭЗХЯ-ыг хариуцагчаар татсан шүүхийн хэрэг маргаанд төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж ажилласан.	Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар МУ-ын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон: -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудад оролцож, дэмжлэг туслалцаа үзүүлэн оролцож байгаа болно: 1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа "Улаан Дөл" ХХК-ийн нэхэмжлэлтэй Үндэсний аудитын газарт холбогдох хэрэгт гуравдагч этгээд Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаа бөгөөд тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл ажлыг гүйцэтгэж, хариу мэтгэлцэх тайлбарын хууль, эрх зүйн судалгаа хийж, боловсруулж, шүүх хуралдаанд оролцсон болно. Тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа болно. 2. "Чингис Лэнд Девелопмент Групп" ХХК-ийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эдийн засаг, хөгжлийн яамыг хамтран хариуцагчаар татан оролцуулахаар заасан байх тул шинжээч Ц.Должинсүрэн болон миний бие итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон тус хэргийн шүүх хуралд оролцохоор удирдлагаас чиглэл авч, хэргийн материалтай танилцаж, хариу тайлбар боловсруулж, шүүх хуралд хамтран оролцохоор бүхий л бэлтгэл ажлыг гүйцэтгэж, шүүх хуралд оролцсон болно. Шүүхээс "Чингис Лэнд Девелопмент Групп" ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн болно. 3.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа "Синапс Мед" ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох захиргааны хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон болно. 4.Бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгжийн холбогдох албан</p>		
--	--	--	--	--	--	--	--

					хаагчдад дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллаж байна.		
4	Долоо хоног бүрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд тус яамны зүгээс хүргүүлсэн саналуудын жагсаалтыг нэгтгэн боловсруулна	Гүйцэтгэлийн явц, хувиар	2024 оны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан.	2025 оны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 30 Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг болон ЭЗХЯ-ны саналын товъёгийг нэгтгэн Төрийн нарийн бичгийн дарга болон Сайдад тухай бүр хүргүүлсэн болно. Мөн түүнчлэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын ирэх 100 хоногийн албан даалгаварт тусгах саналыг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны I-IV улирлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг, Улсын Их Хурлын 2025 оны хаврын болон намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх мэдээллийн сэдвийг (ЭЗХЯ-наас) болон Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын болон намрын ээлжит чуулганаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төслийн мэдээллийг байгууллагын нэгж бүрээс саналыг нь авч нэгтгэн боловсруулж, хүргүүлсэн бөгөөд Төрийн нарийн бичгийн дарга нарын зөвлөлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хуралдааны тэмдэглэлд туссан арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн болно.		
5	Яамны хэмжээнд байгуулах гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, боловсруулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангана	Тухай бүр боловсруулсан, хяналт хэрэгжүүлсэн, хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангасан байдал, хувиар	2024 онд тухай бүр гэрээний төслийг боловсруулж, хяналт хэрэгжүүлж, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангаж ажилласан.	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гэрээний төслүүдийн хууль зүйн үндэслэлийг тухай бүр хянаж, боловсруулж, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангасан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг боловсруулж, хянаж, нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно: -Орон сууцны дэмжлэг олгох журмын ба хөдөлмөрийн дотоод журмын төслийг хамтран боловсруулж эцэслэсэн; -2025 оны Гэрээний нэгдсэн бүртгэл хамтран хөтлөх, дугаар олгох ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн бөгөөд 2024 онд байгуулагдсан гэрээнүүдийг цэгцлэн архивын нэгж үүсгэх ажиллагаанд хамтран оролцсон; -Байгууллагын хөдөлмөрийн гэрээний нэгдсэн төслийн загварыг хамтран боловсруулсан; -Байгууллагын Худалдах,худалдан авах гэрээ,Үйлчилгээ үзүүлэх гэрээ,Ажил гүйцэтгэх гэрээний нэгдсэн загварын төслийг хамтран боловсруулсан; -МУ-ын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон 21 аймгийн Засаг дарга нарын 2025 онд хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан, холбогдох арга хэмжээг яаралтай авч, гарын үсэг зурах үйл ажиллагаанд оролцон албажуулсан болно; -Үйлчилгээ үзүүлэх гэрээний төслүүд (Агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх, Синхрон орчуулгын төхөөрөмж суурилуулах, Орчуулгын үйлчилгээ үзүүлэх, Катеринг, Яамны автомашин засвар, үйлчилгээ үзүүлэх гэрээ г.м.); -Заалны түрээсийн гэрээний төслүүд; -Ажил гүйцэтгэх гэрээний төслүүд (Нүүлгэлтийн ажил гүйцэтгэх, 2025 оны төлөвлөгөөг орчуулах, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний ажил гүйцэтгэх, Судалгаа хийх, системийн шаардлага боловсруулах); -Хөлсөөр ажиллах гэрээний төслүүд (Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтантай байгуулах хөлсөөр ажиллах, Эмчийн); -ХХАГ-ний төслүүд (Лиценз</p>		
--	--	--	--	--	--	--	--

					худалдан авах, Программ хангамж нийлүүлэх тухай, Компьютер тоног төхөөрөмж худалдан авах гэрээ) тус тус боловсруулж, хянаж, засвар өөрчлөлтийг оруулж байгуулсан болно. Байгууллагын албан хаагчдыг тухай бүр шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр ханган ажилласан. Мөн түүнчлэн гэрээ байгуулахтай холбоотойгоор хурал, уулзалтыг зохион байгуулж, хурлын протокол тухай бүр хөтөлж, удирдлагад танилцуулж байсан болно.		
6	Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулна	Гүйцэтгэлийн явц, оролцоо, хувиар	-	Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар дараах хууль, тогтоомжийг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан болно: 1. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах АХ; 2. Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төсөл боловсруулах АХ; 3. Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн АХ; 4. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Бүгд Найрамдах Сингапур	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах тухай АХ; (Хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулж, орчуулж, хэлэлцээр байгуулах бүхий л үйл ажиллагааг хариуцсан); 5. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах тухай хамтарсан АХ; 6. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль (Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу тус хуулийн тандан судалгаа, хэрэгцээ шаардлагын үнэлгээ ажлын даалгавар боловсруулж, тус хуулийн төсөлд санал, дүгнэлт боловсруулж хүргүүлсэн болно); 7. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар Засгийн газраас баталсан төлөвлөгөөний дагуу “Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг сэргээх, дахин байгуулах боломжийг судалж, санал боловсруулах” ажлын</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэнтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох асуудлаар судалгаа хийж, хууль зүйн санал, дүгнэлт боловсруулсан болно; 8. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Засгийн газраас батлагдан, хэрэгжиж байгаа хэм хэм тогтоосон актуудад, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн баталсан "Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж"-ийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, 10 журмыг бүхэлд нь хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг хуульд тусгах ажлыг зохион байгуулах саналыг хүргүүлсэн; 9. Мөн түүнчлэн яамнаас боловсруулсан бусад хуулийн төслүүдэд тухай бүр хууль, эрх зүйн дүгнэлт хийж, санал хүргүүлж байсан болно.</p>		
7	Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хадгалах, хамгаалах,	Гүйцэтгэлийн явц, хувиар	Төрийн болон албаны нууцын тухай хууль болон тогтоомж	Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хадгалах, хамгаалах,	Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хамгаалах, архивлахтай холбоотой ажиллагааг 1, 2 дугаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	100%

<p>ашиглах, тэдгээрт хяналт тавих, архивлах, хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг бодит мэдээ, мэдээллээр хангахтай холбоотой ажиллагааг бүрэн хэрэгжүүлнэ</p>		<p>холбогдох журмуудын хэрэгжилт бүрэн хангагдсан.</p>	<p>ашиглах, тэдгээрт хяналт тавих, архивлах, хариуцсан чиг үүргийн хүрээнд удирдлагыг бодит мэдээ, мэдээллээр хангахтай холбоотой ажиллагааг тухай бүр хэрэгжүүлсэн байна. /100 хувь/</p>	<p>саруудад бүрэн хэрэгжүүлсэн буюу 2024 оны нууц албан бичгүүдэд архивын нэгж үүсгэж, хөтлөн, 2024 онд ирүүлсэн болон хүргүүлсэн нууц албан бичгүүдийг нууц хамгаалах тусгай хамгаалалтын сейфэнд тухай бүр бүртгэл үүсгэн хадгалсан болно. Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хамгаалах, боловсруулахтай холбогдох ажиллагааг шуурхай, тасралтгүй цаг тухайд нь хэрэгжүүлсэн болно. Тайлант хугацаанд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн аливаа нэгэн зөрчил гаргаагүй болно. Яамны бүтэц, стратеги, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагчдын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, ЭБАТ-ны жагсаалтыг шинэчлэн Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж батлуулсан болно. Мөн түүнчлэн Тагнуулын ерөнхий газар болон ЗГХЭГ-тай төрийн нууцад хамаарах гэрээний асуудлаар ТЭЗҮ-ний гэрээний холбогдох бүхий л</p>	<p>сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
--	--	--	---	---	--	--

үйл ажиллагааг үе шаттайгаар нь хариуцан гүйцэтгэсэн болно. Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууц задарч, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, нууц хадгалах, хамгаалах арга хэмжээг авахаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно: -Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан бүрэн эрх, 27, 28 дугаар зүйлд заасан үүргийн хүрээнд эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хуулиар хүлээсэн хариуцлагыг өндөржүүлэн ажилласан; -Жил бүрийн 01 дүгээр сард багтаан Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг боловсруулж ирүүлэх үүргийг 2025 оны 01 дүгээр сард багтаан хүргүүлсэн; - Эрхэлсэн салбар, харьяа байгууллагуудад ТЕГ-аас ирүүлсэн зөвлөмж, зааварчилгаа, үүрэг даалгаврыг уламжлан хүргүүлсэн; -Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг

					шинэчлэн боловсруулсан; - Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл тэмдэглэгээ тавьж бэхжүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй нууцын хууль тогтоомжид заасан загвар, маягт, дардсыг хэрэглэж ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан ажлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлээ ахисан түвшинд дээшлүүлэх	Хариуцсан чиг үүргийн хүрээнд хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлээ ахисан түвшинд дээшлүүлсэн байдал, хувиар	2024 онд өөрийн хариуцсан ажлын чиглэлээр нийт 8 сургалт, семинар, хэлэлцүүлэгт тогтмол хамрагдсан.	Хариуцсан ажлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэн ажилласан байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар дараах хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ахисан түвшин дээшлүүлэх сургалт, семинарт оролцсон болно: 1.Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас зохион байгуулсан "ОУ-ын эрх зүйн орчин үеийн асуудал, цаашдын чиг хандлага сэдэвтэй эрдэм	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>шинжилгээний хурал"; 2.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Хууль тогтоомжийн төсөл, захиргааны хэм хэмжээний актын төсөл болон бодлогын баримт бичиг боловсруулахад анхаарах асуудал" сэдэвт сургалт; 3.Улсын Их Хурлын Тамгын газар, Ханнс-Зайделийн сангийн хамтран зохион байгуулсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар үнэлгээ хийх аргачлал" сэдэвт сургалт; 4.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Нийтийн эрх зүйн нэгдмэл байдал,чиг хандлага,шийдэл" цуврал хэлэлцүүлгийн хүрээнд хийгдсэн "Эрүү,зөрчлийн хууль тогтоомжийн нэгдмэл байдал,эрх зүйн шинэтгэл,чиг хандлага,шийдэл" сэдэвт хэлэлцүүлэг; 5.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулгын төсөл/" сэдэвт хэлэлцүүлэг; 6.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Арилжааны тухай хуулийн төсөл" сэдэвт хэлэлцүүлэг; 7.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Хувийн эрх зүйн шинэтгэл, цаашдын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэг; 8."Эдийн засгийн</p>	
--	--	--	--	--	---	--

					эрх чөлөөний тухай" анхдагч хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг; 9."Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг; 10.Компанийн Засаглалын Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан Компанийн засаглалын сургалт; 11.Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан "Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт"; 12.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны Яамнаас 2025 оны 09 дүгээр сарын 15-наас 28-ны өдрүүдэд Хайкоу хотноо зохион байгуулагдсан "Чөлөөт бүсийн бүтээн байгуулалт, худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих нь" сэдэвт сургалтад тус тус идэвхтэй хамрагдаж; 13."Салбарын хяналтын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан.		
2	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцох	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцох	2024 онд өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд нийт 18 сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон.	Мэргэшүүлэх багц сургалт, холбогдох семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. /100 хувь/	2025 оны жилийн эцсийн байдлаар дараах мэргэшүүлэх сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон болно: 1. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн байгууллагын шинжлэх ухаан, технологи, инновацын паркийн бодлого, туршлагын талаарх үндэсний сургалтын семинар; 2. Уур амьсгалын өөрчлөлтийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

2025

					<p>даван туулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг; 3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл" сэдэвт хэлэлцүүлэг; 4. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт тус тус оролцсон болно. Мөн түүнчлэн яамнаас зохион байгуулсан дараах мэдээллийн цагийн сургалтад хамрагдсан болно: -Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас зохион байгуулсан "Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ" сэдэвт сургалт; - Макро эдийн засгийн бодлогын газраас зохион байгуулсан "Байгууллагын соёл ба ээлтэй орчин бүрдүүлэх" сэдэвт сургалт; -Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газраас зохион байгуулсан "Олон ишт ба ёс зүйн эдийн засаг: Антропологиин чиг хандлага" сэдэвт сургалт; - Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газраас зохион байгуулсан "Үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоо ба стратеги" сэдэвт сургалт - Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газраас зохион байгуулсан "Монгол Улсын гадаад худалдааны</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>санхүүжилт" сэдэвт сургалт; - "Виллиамс коллежийн CENTER FOR DEVELOPMENT ECONOMICS (CDE)" хөтөлбөр болон "АНУ-Д СУРАЛЦАХ БОЛОМЖ" сэдэвт сургалт; - Зөв хооллолт, хүнсний шим тэжээлийн талаар сургалт; - "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж" сэдэвт сургалт; - "Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх" сэдэвт сургалт; -Монгол Улсад тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилтийн ач холбогдол сэдэвт сургалт; -"Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах" сэдэвт сургалт -"Хувь хүний хөгжлийг дэмжих багаар ажиллах ур чадвар" сэдэвт сургалтад тус тус идэвхтэй хамрагдсан болно.</p>	
--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Дашням Ариунбилэг /  /

Огноо: 2025.12.15.

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Хишигбаатар Саруул /  /

Огноо: 2025.12.15.

